

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 08 сарын 05

Эмээл толгой

ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО НЬ: Сум орон нутгийг 2020-2024 онд хөгжүүлэх ард иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлж, төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, тулгамдаж буй асуудал, цаашдын хөгжлийн талаар баримтлах бодлогын баримт бичиг болно.

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Орлоготой иргэн

- 1.1.1 Иргэддээ ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төрөлжсөн богино хугацааны сургалтуудыг зохион байгуулна.
- 1.1.2 Сумандаа жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж хөнгөлөлттэй зээлд хамруулна.
- 1.1.3 Сумын хэмжээнд байнгын шинэ ажлын байр бий болгосон үйлдвэрлэгчдийг ажлын байраар хангах, үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжиж, хөнгөлөлттэй зээл, төслөөр дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.1.4 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийн мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.1.5 Хөдөө орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.6 Шинээр ажлын байр нэмэгдүүлсэн иргэд аж ахуйн нэгжийг татварын хөнгөлөлт, урамшууллын бодлогоор дэмжинэ.

1.2. Хуримтлалын нэгдсэн сан ба орон сууцтай өрх

- 1.2.1 Сумын төвийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлж инженерийн нэгдсэн шугам сүлжээтэй орон сууцны тоог нэмэгдүүлнэ.
- 1.2.2 Сумын төвийн дулааны шугамыг өргөтгөж, хувийн орон сууцны тоог нэмэгдүүлэх бодлого барина.

1.3. Эрүүл иргэн

- 1.3.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна.
- 1.3.2 Эрүүл мэндийн оношилгооны чадавхыг дээшлүүлж, эмч мэргэжилтнийг нарийн мэргэжлээр бэлтгэн иргэн бүр бүрэн эрүүл мэндийн үзлэг оношилгоонд жил бүр заавал хамрагдах тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.3.3 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлж, орон нутгийн оношилгоо мэдээллийг дээд шатлалын эмнэлгүүдтэй цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.

Т.М.

000000001



- 1.3.4 “Элэг бүтэн Баянхонгор” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.5 Эмэгтэйчүүдийн товлотт дархлаажуулалтыг сумын хэмжээнд нэвтрүүлж, умайн хүзүү, хөхний хорт хавдраас сэргийлэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн “Энх бүсгүй” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.
- 1.3.6 Эрүүл мэндийн байгууллагын ёс зүйн салбар хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулан, нийгэмд эерэг хандлагыг бий болгоход чиглэсэн “Эрүүл мэндийн салбарын эелдэг ажилтан” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.
- 1.3.7 Суманд шинэ эрүүл мэндийн төв барьж, иргэдэд үйлчлэх хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.4. Чанартай боловсрол

- 1.4.1. Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгт сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.2. Ерөнхий боловсролын сургуульд тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах дохионы хэлний багш бэлтгэхэд дэмжин ажиллана.
- 1.4.3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны стандартыг хангуулж ажиллана.
- 1.4.4. Өдөр өнжүүлэх бүлгийн ажиллах журмыг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4.5. Иргэдийн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4.6. Хувь хүн, гэр бүл, байгууллагын соёлыг төлөвшүүлэх бодлого боловсруулна.
- 1.4.7. Байдраг ахлах сургуульд 240 хүүхдийн суудалтай хичээлийн байр, спорт заалны хамт шинээр барьж ашиглалтад оруулна.
- 1.4.8. Суманд шинээр цэцэрлэг барина.

1.5. Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр

- 1.5.1. Хүүхдийн хөгжил, хамгаалал, төлөвшлийг сайжруулах орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.2. Хүүхэд, багачуудын бие даах чадварыг нэмэгдүүлж, хөгжүүлж, тэдний төлөвшлийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 1.5.3. Хүүхдийн хүчирхийлэл, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна.
- 1.5.4. Сумын хүүхдийн зөвлөл, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулж, гэр бүл, хүүхэд хамгааллын асуудлыг бодлогын төвд байлгана.

1.6. Залуучуудыг дэмжих чиглэлээр

- 1.6.1. Залуучуудын хөгжил төлөвшлийг сайжруулж, нийгмийн оролцоог нэмэгдүүлж, идэвхтэй амьдралыг нь дэмжсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.6.2. “Залуус бидний төлөө-бид залуусын төлөө” төсөл хэрэгжүүлж, залуусын оролцоотой төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах бодлого хэрэгжүүлнэ.



000000002

Төрийн захирлын
 6477
 ЮА000

- 1.6.3. Залуу гэр бүлийг дэмжсэн бодлого боловсруулан, гэр бүл төлөвлөлт, харилцаа хандлагыг дээшлүүлсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.7. Үндэсний бахархал, өв соёл, спорт

- 1.7.1. Соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулж, дэмжлэг үзүүлнэ.
- 1.7.2. Тахилгат уул, ус, газар нутгийн мэдээллийн санг бүрдүүлж, тахин шүтэх ёсыг түгээн дэлгэрүүлэх журам боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 1.7.3. Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлж, спорт талбайн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.
- 1.7.4. Түүх соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж Соёлын өвийг хадгалан хамгаалж, өвлүүлэн, баяжуулан хөгжүүлж буй соёлын биет бус өв тээгч нарыг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.7.5. Хоёр жилд 1 удаа соёл урлагийн өдрүүдийг суманд зохион байгуулж ардын авьяастнуудыг нийтэд сурталчилж, алдаршуулна.
- 1.7.6. Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг хөдөөд чиглүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлээр хангана.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Эдийн засаг, үйлдвэржилтийн бодлого


- 2.1.1 Иргэн, айл өрх бүр хуримтлал үүсгэн эдийн засгийн хямралд өртөхөөс сэргийлэх, мөнгөн урсгалыг дотооддоо хадгалан, өрхийн төсөв болон аймаг орон нутгийн эдийн засагт эергээр нөлөөлөх “Хуримтлалтай хонгорчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.1.2 Барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих, блокийн үйлдвэрлэлийг өргөтгөж, хөгжүүлнэ.
- 2.1.3 Сумын төвийн цахилгааны шугам сүлжээний хүчин чадлыг сайжруулна.
- 2.1.4 Соёлын төв, спорт заалны их засварыг хийж, соёлын төвийг сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангана.
- 2.1.5 Орон нутгийн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөн төсвийн орлогын бүрдэлтийг сайжруулж, санхүүгийн алдаа зөрчлийг бууруулах, салбарын боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах зорилгоор “Тунгалаг санхүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2. Төрөлжсөн аялал жуулчлал

- 2.2.1 Сумд аяллын маршрут, брэнд бүтээгдэхүүн үйлчилгээтэй болж аймгийн аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд холбогдох, “Хот айл-жуулчны бааз” төсөл хэрэгжүүлж малчин өрхүүд жуулчин хүлээн авч, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.2 Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа, аж ахуйн нэгж, иргэдэд хүү багатай, хөнгөлөлттэй зээл олгож үйл ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр дэмжиж ажиллана.

2.3. Дэд бүтэц

- 2.3.1 Орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийг ая тухтай орон сууцаар хангана.
- 2.3.2 Нэгдсэн халаалтын системийг өргөтгөж айл өрхүүдийг холбоно.

 000000003

143544
57 9007

- 2.3.3 Гудамж талбайн гэрэлтүүлэг, тохижилтыг хийж гүйцэтгэнэ.
- 2.3.4 Сумын нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж эхэлнэ.
- 2.3.5 Үүрэн телефонуудын сүлжээний хамрах хүрээг өргөтгөнө.
- 2.3.6 Сумын төвийн гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.

2.4. Авто зам

- 2.4.1 Жаргалант суманд 2 км авто зам тавина.

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО



- 3.1 Нутгийн удирдлагын ордныг шинээр барьж, ашиглалтад оруулна.
- 3.2 Эмээл толгойн 4-р багийг конторын байртай болгоно.
- 3.3 Төрийн байгууллага бүрд төрийн албан хаагчийн “Нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр, төрийн албан хаагчийн “Сургалтын хөтөлбөр”-ийг батлуулан хэрэгжүүлнэ.
- 3.4 Төрийн албаны хүнд суртал, ашиг сонирхлын зөрчлийг бүрэн арилгаж, иргэн төвтэй засаглалыг бүрдүүлнэ.
- 3.5 Төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломж бүхий цахим системийг нэвтрүүлнэ.
- 3.6 Төрийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь чанаржуулж тогтмолжуулна.
- 3.7 Төрийн байгууллагуудын дотоод дэг журам, алба хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулж, ажлын чанар, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- 3.8 Шаардлагатай төрийн байгууллагуудад авто машины парк шинэчлэлт хийнэ.
- 3.9 Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын хулгайтай тэмцэхэд иргэн, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг дэмжих замаар мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 3.10 Гамшгийн үеийн бэлэн байдлыг сайжруулж, эрсдэлээс хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 4.1 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг боловсронгуй болгож, төр хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлээр хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулна.
- 4.2 Түүх, соёлын дурсгалт газар, ус, ой, ховор амьтан, ургамлын тархац бүхий нутаг, өвөрмөц тогтоцтой эко системийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч, тухайн бүс нутагт ажиллаж амьдарч буй иргэд, бүлэг нөхөрлөлтэй хамтран хамгаалалтын оновчтой бодлого хэрэгжүүлнэ.
- 4.3 Зэрлэг ан амьтдад хоол тэжээлийн био техникийн арга хэмжээг тогтмол авна.
- 4.4 Сумын төвийн тохижилтын хүрээнд айл өрх, албан байгууллага бүх нийтийн эзэмшил газруудыг тохижуулах, зүлэгжүүлэх, мод тарих ажлыг бүх нийтийн ажил болгон хэрэгжүүлнэ.

ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 5.1 Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх "Илгээлтийн эзэн-III" аяныг хэрэгжүүлж, Малжуулах төслийн үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.



000000004

- 5.2 Мал аж ахуй түүхий эд, мах, махан бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ бий болгож малчид, мал бүхий иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 5.3 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын гений санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.
- 5.4 Нутгийн шилмэл омог, үүлдрийн малыг өсгөн, эдийн засгийн эргэлтэд оруулж, таваарлаг чанарыг сайжруулна.
- 5.5 Малын халдварт өвчин тархах, давтамжийн судалгааг үндэслэн мал эмнэлгийн цогц арга хэмжээг эрчимжүүлж, эрүүл бүс нутаг гэсэн статусаа баталгаажуулна.
- 5.6 Мал угаалгын ванны тоог нэмэгдүүлнэ.
- 5.7 Арьс шир боловсруулах цех байгуулж ажиллана.
- 5.8 Сумын хэмжээний малчид, төлчдийн зөвлөгөөнийг зохион байгуулж, нутгийн мал сүргийг сурталчлах ажлуудыг зохион байгуулна.
- 5.9 Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, сум багийн нэрийн брэнд бүтээгдэхүүнтэй болгоно.
- 5.10 Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
- 5.11 Бэлчээрийг нөхөн сэргээх, малчдын дундын фонд байгуулна.
- 5.12 Чацарганы тариалалтыг дэмжиж, ундааны цех байгуулна.

_____оОо_____



000000005